



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:**

Газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ОНА менежер:
Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: odgerell@audit.gov.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс ба шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Аудитор: Д.Уртнасан
Утас: 261628
Цахим хаяг:
urtnasand@audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр
Бага тойруу-6 Улаанбаатар-46
Монгол Улс
Цахим хуудас: www.audit.mn

2014 оны 4 дүгээр сар

Оршил

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулахаар өгсөн зөвлөмж, түүний хариуг тусгасан болно.

Тус төсвийн багцын Санхүүгийн байдлын тайланд 2013 оны эцэст 22,645.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 33,338.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр тус тус толилуулсан байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдынтөсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд 85 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэж, нийт төсвийн 22хувьд Үндэсний аудитын газар, 50 хувьд Аймаг, нийслэлийн аудитын газрууд, 2 хувьд хараат бус аудитын компаниуд тус тус аудит хийжээ.

Хан Хөхийн нурууны Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчин шинжилгээний газар, Төв аймгийн Ус, цаг уур, орчин шинжилгээний газар, Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа,Горхи тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд “Хязгаарлалттай” Тахь нутагшуулах эрдэм шинжилгээний төв Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд, /А, Б хэсэг/ Монгол элсний БЦГ-ын хамгаалалтын захиргаанд тус тус “Сөрөг” санал дүгнэлт, нийт төсвийн багцын 62,765.6 сая төгрөгийн буюу 80.3 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хэрэгжүүлдэг хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархөөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

УЦУОШГ-ын дотоод аудит орон нутгийн 2013 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, даргын тушаал, хурлын тэмдэглэл, ажил дүгнэсэн материал, 2013-2014 оны төсвийн төсөл, 2013 оны батлагдсан төсөв, тодотгол, 2013 оны санхүүгийн баримт, үндсэн хөрөнгө, бараа материалын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны салбарын байгууллагуудад ҮАГ, аймаг, нийслэлийн Аудитын газар болон ҮАГ-ын нэрийн өмнөөс гэрээгээр аудит хийж буй хараат бус аудитын компаниудын хийсэн аудитаар илэрсэн зарим асуудлыг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтын талаар

- УЦУОШГ модем, сүлжээний төлбөрийн гадаад валютаарх гүйлгээг хийхдээ Монгол банкны тухайн өдрийн зарласан ханшаар бус төрийн банкны ханшаар тооцсоноос 2.2 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, ажилчин албан хаагчдын цалинг тогтоохдоо Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамаарал бүхий цалингаасхэтрүүлэн тогтоосон,
- Мөн нэг удаагийн тэтгэмжийн зардлаас цаг уурын өдрийг тэмдэглэх арга хэмжээнд 1.3 сая төгрөгийг Ти Си ТИ ХХК-руу шилжүүлж зориулалт бус зардал гаргасан байна.

2. Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, ангилал, худалдан авалтын талаар

- Төв аймгийн УЦУОШГ хөрөнгө актлахдаа холбогдох албан тушаалтны шийдвэргүй, хөрөнгө актлах тухай өмч хамгаалах комиссын хурлын тэмдэглэл байхгүй байхад тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн 2.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасч, акталсан байна.
- Хөвсгөл аймгийн УЦУОШГ үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 28.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэж, шууд зардал болгосон байна.
- Цэвэр агаар сангаас Өвөрхангай аймгийн УЦУОШГ-тхуваарилсан47.3 сая төгрөгийн агаар дахь тоосонцорыг хэмжих иж бүрэн багаж, Дорнод аймгийн УЦУОШГ“Цэцүүх” ХХК-ийн нийлүүлсэн 10.0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг тус тус үндсэн хөрөнгөнд бүртгэж орлогод аваагүй байна.
- Цэцэг мянган угалзатын байгалийн цогцолборт хамгаалалтын захиргаа нь “Алтай Соёны” төсөлд ашиглагдаж байсан яамны хөрөнгө оруулалтаар их засвар хийгдэж, капиталжуулсан барилгыг эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүйгээс үндсэн хөрөнгийн орлогод аваагүй байна.
- НББ-ийн тухай хуулийн 11.2.1-ийг зөрчиж, Монгол элсний Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа 121.3 сая төгрөгийн, Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны Б хэсэг 35.3 сая төгрөгийн хөрөнгийг тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3. Авлага, өглөгийн талаар

- УЦУОШГ 9.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, 415.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг өглөг авлагын журналаар дамжуулалгүй зардалд бичсэн байна.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын 109.5 сая төгрөгийн өглөг, 140.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
-

4. Санхүүгийн тайлагналын талаар

- Төв аймгийн УЦУОШГ Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө дансны төсвийн хөрөнгөөр худалдаж авсан хөрөнгөнд үнэ төлбөргүй нийлүүлсэн 134.1 сая төгрөгийн хөрөнгийг дутуу тайлагнасан,
- Мөн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн бараа үйлчилгээний орлого хэсэгт тусгасан үнэ төлбөргүй ирсэн барааны орлогыг хүлээн зөвшөөрсөн дүн бараа материалын тодруулгын тайлангийн хандиваар болон шилжүүлэн авсан дүнтэй 14.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Нийгмийн даатгалын хэлтсээс жирэмсний болон амаржсаны тэтгэмжинд олгосон нийт 15.7 сая төгрөгийн санхүүжилтийг орлого бууруулах бичилт хийж бусад орлогын дансыг цэвэрлэх гүйлгээ хийгээгүй орлогоор тайлагнасан байна.
- 2013 оны эцэст Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын санхүүгийн тайланд тусгагдсан 186.0 сая төгрөгийн бараа материал, 2,659.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
- Хан Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 36.6 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэн нийлүүлснээр тайлагнасан байна. /Дээрх алдаануудыг аудитын явцад залруулга хийсэн/
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/161 дүгээр тушаалаар нийт 14 дансдын 2 дугаар гарын үсэг зурах эрхийг Ерөнхий нягтлан бодогчид олгожээ.
- Мөн Ерөнхий нягтлан бодогч Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй хирнээ санхүүгийн баримтанд 2 дугаар гарын үсэг зурж, ажил гүйлгээ хийсэн байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 65.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 58.2 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 11.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоон, 174.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, нийт 34 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ҮАГ-аас 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдад 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 48 зөвлөмж өгөгдсөн, зөвлөмжийн биелэлт 83.9 хувьтай байна.

Аудитын санал дүгнэлт

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын санхүүгийн тайланд илэрхийлсэн 109.5 сая төгрөгийн өглөг, 140.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2013 оны эцэст 186.0 сая төгрөгийн бараа материал, 2,659.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, Сайдын нийт төсвийн 27.9 хувийг эзэлж буй Цэвэр агаар сангийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд ирүүлээгүй, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан 1.2 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байгаа зэрэг нь санхүүгийн тайланд өгөх бидний санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэж байна.

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 700

танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны удирдлага Төсвийн тухай хуулийн 54.2,54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын санхүүгийн тайланд илэрхийлсэн 109.5 сая төгрөгийн өглөг, 140.0 сая төгрөгийн авлагын тооцоог тооцоо нийлсэн актаар

070487

баталгаажуулаагүй, 2013 оны эцэст 186.0 сая төгрөгийн бараа материал, 2,659.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, Сайдын нийт төсвийн 27.9 хувийг эзэлж буй Цэвэр агаар сангийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд ирүүлээгүй, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан 1.2 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан зэрэг нь санхүүгийн тайланд өгөх бидний санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэж байна.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Аудитын дүгнэлтийн талаар

Асуудал 2

Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Асуудал 3

Хариуцлага тооцох талаар

Асуудал 4

Ажил үүргийн хуваарийн талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгддэг. Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд таны зүгээс эдгээр аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх талаар анхаарал тавина гэдэгт найдаж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, харьяа байгууллагуудын санхүүгийн ажилтнууд болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

2013 оны Санхүүгийн тайлангийн аудитаар Хан Хөхийн нурууны Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчин шинжилгээний газар, Төв аймгийн Ус, цаг уур, орчин шинжилгээний газар, Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа, Горхи тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд тус тус “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн байна.

Мөн Тахь нутагшуулах эрдэм шинжилгээний төв Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд, Монгол элсний БЦГ-ын хамгаалалтын захиргаанд тус тус “Сөрөг” санал дүгнэлт өгөгджээ.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, 4 хоног хоцроосон.

Эрсдэл

Мэргэжлийн мэдлэг чадвар дутмагаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдож, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, зарцуулалтанд тавих дотоод хяналт алдагдах;

ҮАГ-ын зөвлөмж

2013 оны Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан газрууд болон Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан хугацаанаас хоцроож, ирүүлсэн холбогдох ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу хариуцлага тооцох;

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

ҮАГ-ын ажиглалт

Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын байгууллагуудын санхүүгийн тайлангийн чанар байдал, аудитын дүнг нэгтгэн холбогдох арга хэмжээ авахгүйгээс Санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

2012 оны Санхүүгийн тайлангаар салбарын хэмжээнд өгөгдсөн зөвлөмжийн биелэлт 83.9 хувьтай байна.

Тухайлбал: УЦУОШГ-ын хэмжээнд 2012 оны санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, аудитаар тавигдсан төлбөрийн актыг бүрэн барагдуулаагүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайланг буруу илэрхийлэгдэх, өмч хөрөнгө үрэгдэх нөхцөл бүрдэх;

ҮАГ-ын зөвлөмж

Салбарын удирдах ажилтнуудын ажлыг дүгнэхдээ санхүүгийн үйл ажиллагааны чанар байдал, аудитын дүнг харгалзаж байх;

Төсвийн шууд захирагчийн эрх үүргийн талаарх сургалтыг зохион байгуулах, дотоод хяналтыг сайжруулах;

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 дүгээрсарын 1-ний дотор ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана.

ҮАГ-ын ажиглалт

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын 2013 оны Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд ирүүлээгүй, 109.5 сая төгрөгийн өглөг, 140.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Санхүүгийн тайланд илэрхийлсэн 186.0 сая төгрөгийн бараа материал, 2,659.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Эрсдэл

Өмч хөрөнгө үрэгдэх нөхцөл бүрдэх, эзэнгүйдэх, данс бүртгэлд буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ын зөвлөмж

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоог бодох, 109.5 сая төгрөгийн өглөг, 140.0 сая төгрөгийн авлагын тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулах;

Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх;

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана.

ҮАГ-ын ажиглалт

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 сарын 22-ний өдрийн А/161 дүгээр тушаалаар нийт 14 дансдын 2 дугаар гарын үсэг зурах эрхийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчид олгожээ.

Мөн Ерөнхий нягтлан бодогч Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй хирнээ санхүүгийн баримтанд 2 дугаар гарын үсэг зурж, ажил гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 19.2-д “Энэхуулийн 14.1.3, 14.1.7, 14.1.8, 14.1.11, 14.1.12, 14.1.16-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна.

19.3-т “Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна.” гэж заасныг тус тус зөрчжээ.

Эрсдэл

Бүртгэлээр тавих хяналт сулрах, ажлын ачаалал хэт ихсэх, хариуцлага сулрах;

ҮАГ-ын зөвлөмж

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны тухайн ажил хариуцсан санхүүгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг дахин хянаж, эрх бүхий албан тушаалтнуудын хяналт тавих эрх, үүрэг, ажлын ачааллыг харгалзан оновчтой зохион байгуулах;

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг 2014 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛС	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Банкинд байгаа бэлэн мөнгө	770,818,793.88	7,834,741,180.20
Төгрөг	770,818,793.88	7,834,741,180.20
Төсөвт байгууллагын харилцах	338,195,783.50	7,008,704,762.37
Тусгай зориулалтын сангийн харилцах	-	498,923,996.15
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	432,623,010.38	39,232,605.08
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	287,879,816.60
АВЛАГА	8,793,755,525.28	595,030,785.73
Ажиллагчидтай холбогдсон авлага	27,360,240.54	62,389,988.98
Төлбөртэй үйлчилгээний авлага	573,095.07	243,095.07
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	5,796,488,315.16	-
Бусад авлага	2,969,333,874.51	532,397,701.68
Байгууллагаас авах авлага	2,947,569,717.69	311,374,983.61
Гэрэл цахилгааны авлага	1,871,655.00	-
Цэвэр бохир усны авлага	473,700.00	-
Дотоод албан томилолтын авлага	8,000.00	-
Хоолын авлага	-	135,272.00
Шуудан холбооны авлага	-	70,498.80
Бусад зардлын тооцооны авлага	2,945,216,362.69	311,169,212.81
Хувь хүмүүсээс авах авлага	21,764,156.82	221,022,718.07
УРЬДЧИЛГАА	16,664,074,980.13	8,594,245,434.00
Бусад урьдчилгаа	16,664,074,980.13	8,594,245,434.00
Урьдчилгаа тооцоо	1,691,506.13	2,550,000.00
Цалингийн урьдчилгаа	1,691,506.13	2,550,000.00
Урьдчилж гарсан зардал	16,662,383,474.00	8,591,695,434.00
Урьдчилж төлсөн зардал	16,662,383,474.00	8,591,695,434.00
БАРАА МАТЕРИАЛ	4,568,293,704.40	5,619,315,020.03
Түүхий эд материал	1,943,649,384.59	1,698,289,241.62
Тусгай зориулалттай материал	1,893,156,733.39	1,698,289,241.62
Бэлэн бүтээгдэхүүн	50,492,651.20	-
Хангамжийн материал	2,516,490,062.81	3,707,210,746.41
Бичиг хэргийн материал	168,669,737.12	137,133,548.47
Аж ахуйн материал	940,624,644.88	1,448,314,454.18
Сэлбэг хэрэгсэл	294,004,480.13	725,120,632.02
Түлш, шатах тослох материал	33,995,105.06	55,555,563.18
Барилгын засварын материал	13,269,441.30	11,604,825.40
Хүнсний материал	5,319,076.00	6,082,047.00
Малын тэжээл	19,200.00	5,437,650.00
Баглаа боодол	28,257,200.90	17,496,054.50
Бусад бараа материал	1,032,331,177.42	1,300,465,971.66
Мал амьтад	83,003,232.00	87,052,932.00
Бусад	25,151,025.00	126,762,100.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,840,410,778.68	22,645,837,687.61
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,979,599,691.50	31,338,086,998.83
Биет хөрөнгө	24,853,873,931.89	31,138,757,142.93

Барилга, байгууламж, орон сууц	8,924,668,667.76	16,064,119,682.33
өртөг		
Барилга, байгууламж орон сууц - Анхны	13,827,391,679.23	21,272,086,289.38
Хуримтлагдсан элэгдэл	(4,902,723,011.47)	(5,207,966,607.05)
Авто-тээврийн хэрэгсэл	3,077,158,457.04	2,199,635,704.03
Анхны өртөг		
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг -	6,804,634,477.72	6,167,145,576.69
элэгдэл	(3,727,476,021.68)	(3,967,509,872.66)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,932,594,741.71	9,132,021,505.61
Анхны өртөг		
Машин тоног төхөөрөмж(компьютер) -	17,023,344,008.58	19,372,219,000.03
Хуримтлагдсан элэгдэл	(8,090,749,266.87)	(10,240,197,494.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,160,114,301.91	1,224,426,621.23
өртөг		
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны	2,469,674,368.28	2,576,860,886.77
Хуримтлагдсан элэгдэл	(1,309,560,066.37)	(1,352,434,265.55)
Зам, гүүрийн байгууламж	19,427,191.89	17,213,828.28
Анхны өртөг		
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	68,513,261.15	69,821,261.15
Хуримтлагдсан элэгдэл	(49,086,069.26)	(52,607,432.87)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	808,896,078.58	989,665,698.08
Анхны өртөг		
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж - Анхны өртөг	816,674,286.41	997,608,294.64
Хуримтлагдсан элэгдэл	(7,778,207.83)	(7,942,596.56)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,174,000,000.00	1,222,636,000.00
Бусад үндсэн хөрөнгө	250,933,652.01	178,021,381.37
Анхны өртөг		
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	403,145,468.23	323,067,108.83
элэгдэл	(162,437,305.22)	(159,217,016.47)
Номын фонд	10,225,489.00	14,171,289.01
Дуусаагүй барилга, байгууламж	506,080,841.00	111,016,722.00
Биет бус хөрөнгө	125,725,759.61	199,329,855.90
Програм хангамж	117,808,032.55	199,144,729.54
Анхны өртөг		
Програм хангамж - Анхны өртөг	296,827,760.40	421,922,039.82
элэгдэл	(179,019,727.85)	(222,777,310.28)
Бусад биет бус хөрөнгө	7,917,727.06	185,126.36
Анхны өртөг		
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	22,482,435.00	1,198,071.00
элэгдэл	(14,564,707.94)	(1,012,944.64)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	55,820,010,470.18	53,983,924,686.44
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,271,073,577.04	8,355,141,476.76
Өглөг	7,271,073,577.04	8,200,299,287.50
Ажилчидтай холбогдсон тооцоо	37,598,894.42	132,713,933.04
Цалингийн өглөг	285,112.71	1,184,212.11
НДШ-ийн өглөг	24,561,349.71	109,421,577.83
ХАОАТ-ын өглөг	12,266,381.00	22,094,443.10
ҮЭ-ийн өглөг	486,051.00	13,700.00
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	1,929,818.00	7,312,674.00

Түлш халаалтын тооцоо	-	49,178.00
Шуудан холбооны тооцоо	(0.00)	1,106,647.00
Тээвэр шатахуунын тооцоо	-	948,181.00
Хоолын тооцоо	659,000.00	1,930,523.00
Бусад зардлын тооцоо	1,270,818.00	3,278,145.00
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	32,891,091.00	-
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	-	25,000.00
Бусад өглөг	7,198,653,773.62	8,060,247,680.47
Байгууллагад төлөх өглөг	7,194,055,909.62	8,053,082,040.48
Хувь хүмүүст төлөх өглөг	4,597,864.00	7,165,639.99
Урьдчилж орсон орлого	-	154,842,189.26
Төсөвт байгууллага	-	154,842,189.26
Урьдчилж орсон орлого	-	154,842,189.26
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,271,073,577.05	8,355,141,476.76
Засгийн газрын хувь оролцоо	48,548,936,893.13	45,628,783,209.68
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	29,336,962,457.75	25,978,482,116.58
Хуримтлагдсан үр дүн	16,801,471,072.96	17,289,419,443.44
Өмнөх үеийн үр дүн	16,801,471,072.96	16,316,531,725.73
Тайлант үеийн үр дүн	-	972,887,717.71
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,410,503,362.42	2,360,881,649.66
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	48,548,936,893.13	45,628,783,209.68
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	55,820,010,470.18	53,983,924,686.44

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТАТВАРЫН ОРЛОГО	3,063,879,184.90	88,065,225.70
Бараа, үйлчилгээний албан татвар	3,063,879,184.90	88,065,225.70
Зарим төрлийн барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн татвар	3,063,879,184.90	88,065,225.70
Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	3,063,879,184.90	88,065,225.70
Агнуурын нөөц ашигласны төлбөр	3,063,879,184.90	88,065,225.70
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,725,340,977.18	70,428,026,968.40
Гадаад орнуудаас үзүүлсэн	5,725,340,977.18	203,039,699.47
Урсгал	206,208,991.20	203,039,699.47
Олон улсын байгууллагын тусламж	206,208,991.20	1,359,290,291.33
Урсгал тусламж	77,637,154,999.55	1,359,290,291.33
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	72,412,525,598.56	68,865,696,977.60
Улсын төвлөрсөн төсвөөс	64,734,806,497.69	68,131,173,512.40
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	122,393,700.00	60,046,031,669.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	7,555,325,400.87	72,832,824.70
Хөрөнгийн	362,726,376.00	4,113,353,363.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	270,382,726.00	3,898,802,655.70
ТӨрийн болон орон нутгийн Өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	26,780,050.00	665,121,082.70
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөнөөс	65,563,600.00	720,302,462.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		2,489,782,711.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		23,165,600.00
Төсвийн урамшуулал	4,820,201,072.99	430,800.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	4,820,201,072.99	153,000.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	41,701,952.00	28,019,060.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	41,701,952.00	28,019,060.00
Төсөвт байгууллагаас		595,462,771.20
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		595,462,771.20
Нийгмийн даатгалын сангаас		111,041,634.00
НДС-ийн шилжүүлэг		111,041,634.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,075,316,191.89	12,456,472,734.13
Өмчийн орлого	16,073,342,003.89	71,171.17
Хүүгийн орлого	16,073,342,003.89	71,171.17
Бараа, үйлчилгээний борлуулалт	367,475,324.68	12,456,401,562.96
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	15,611,359,308.26	12,456,401,562.96
Үндсэн үйл ажиллагааны орлого	94,507,370.95	427,319,956.31
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,974,188.00	1,566,545,380.65
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого		10,462,536,226.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	102,707,900,344.72	82,972,564,928.23
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	22,215,988,767.34	23,307,849,767.12

Үндсэн болон нэмэгдэл цалин	20,024,360,670.03	21,069,088,381.91
Үндсэн цалин	19,661,849,352.03	19,702,867,678.41
Гэрээт ажилчдын цалин	44,816,000.00	379,741,346.50
Унаа хоолны хӨнгӨлӨлт	317,695,318.00	121,450,702.00
Бусад нэмэгдлүүд	15,673,057.00	865,028,655.00
Үр дүнгийн урамшуулал	1,387,300.00	48,749,512.00
Унаа, болон бусад нӨхӨн олговор	300,634,961.00	814,225,488.00
Бусад нэмэгдэл		2,053,655.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	2,191,628,097.31	2,238,761,385.21
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	1,810,090,157.68	1,847,780,741.17
Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,425,073,767.30	1,446,780,691.40
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	98,767,599.12	158,359,115.51
ҮОМШ Өвчний даатгалын шимтгэл	190,555,111.91	194,810,206.28
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	95,693,679.35	47,830,727.98
Эрүүл мэндийн даатгалын хураамж	381,537,939.63	390,980,644.04
УРСГАЛ ЗАРДАЛ	53,647,055,204.71	44,259,651,012.79
Бараа үйлчилгээний урсгал зардал	6,886,560,392.41	28,220,532,743.66
Тогтмол зардал	723,066,758.59	848,000,580.06
Гэрэл цахилгаан	186,946,596.00	265,833,603.40
Түлш, халаалт	489,805,639.10	534,429,989.22
Цэвэр, бохир ус	46,314,523.49	47,736,987.44
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		2,680,400.00
Хоол		2,680,400.00
Бусад бараа үйлчилгээний зардал	6,163,493,633.82	27,369,851,763.60
Бичиг хэргийн зардал	98,493,007.26	178,017,128.69
Тээвэр, шатахуун	516,855,720.97	608,417,956.73
Шуудан, харилцаа холбоо	160,824,635.35	171,458,102.57
Дотоод албан томилолт	528,597,014.01	837,649,148.10
Гадаад албан томилолт	88,679,330.85	68,170,485.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	13,070,001.00	71,859,952.19
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	26,215,726.00	47,672,061.00
Сургалт семинарын зардал	65,120,727.00	304,281,068.50
Эрдэм шинжилгээний ажил хийх	178,941,140.95	233,895,876.00
Жижиг эд хогшил худалдан авах	281,155,658.80	644,000,679.01
